

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУМЫН ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ АРГАЧЛАЛЫН ДАГУУ ҮНЭН
ЗӨВ ТООЦОЖ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2022/30-20-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Э.Бат-Эрдэнэ

Аудитор

З.Даваадорж

Г.Ичинхорлоо

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2022 оны 06 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал, хавсралт

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

**Бүлэг 1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас
сумын хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг
аргачлалын дагуу үнэн зөв тооцож хуваарилаагүй
байна.**

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль,
журамд заасан эх үүсвэрийн дагуу бүрэн бүрдүүлээгүй,
сумын ОНХС-д олгох хөрөнгийг шилжүүлэг тооцож
аргачлалын дагуу үнэн зөв тооцож, хуваарилаагүй
байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим
хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн
бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.

**Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
“Хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын
хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө, үр дүн
буурч байна.**

2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сангийн
зориулалтад нийцээгүй зарим төсөл, арга хэмжээг
санхүүжүүлсэн байна.

2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын зорилго,
зорилт, хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө
нь буурч байна.

2.3 Эрх бүхий байгууллагаас ОНХС-ийн хөрөнгөөр
хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт,
хадгалалт, хамгаалалтад анхаарал хандуулаагүйгээс
зарим өмч, хөрөнгө эзэнгүйдсэн, үр ашгаа өгөөгүй байна.

**Бүлэг 3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн
талаар Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй
мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авах
боломжоор хязгаарлагдаж байна.**

3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл,
арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн
явцад шат шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн
төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын
мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв
мэдээллийг авах боломжгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХөТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХШУДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ШХА	Шууд худалдан авалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/10

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2 дахь, 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ, болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Э.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.


3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын биелэлтийг акт, албан шаардлагад заасан хугацаанд, зөвлөмжийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг), аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан), аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ариунбат), Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсоргодог), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Оюунтуяа), Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Б.Янжиндолгор), сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр), ахлах аудитор (Э.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитыг баг (З.Даваадорж, Г.Ичинхорлоо)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Аудитаар тогтоосон төлбөрийн акт,
өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын дүн
1	Төлбөр барагдуулах тухай	Аймгийн Засаг дарга	12/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	2,640,000
2	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	60/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	5,400,000
3	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	61/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	4,640,000
4	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	62/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	-
5	Зөрчил арилгах тухай	Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс	63/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	87,246,200
6	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	64/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	182,900,000
7	Зөрчил арилгах тухай	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	65/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	151,800,000
8	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	66/A2250433/ХӨА-2022/30-20-ШТА-ГА	-

--ooOoo--

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа Засаг даргын Тамгын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, Барилга захиалагчийн хяналтын төв, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын тамгын газар, баг хорооны дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон бусад холбогдох төрийн байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг Хөвсгөл аймгийн хэмжээн дэх Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт болон холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах,

холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитор О.Ганболд, З.Даваадорж, Г.Ичинхорлоо нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2021 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.


Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүчин зүйлс: Орон нутаг дахь Төрийн аудитын газар нь төрөлжсөн хэлбэрээр аудитыг гүйцэтгэх боломжгүй байдаг тул аудитын хугацаанд санхүүгийн тайлангийн аудит, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн гүйцэтгэлийн аудитуд давхацсан тул цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байлаа.

Ерөнхий мэдээлэл: Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан хэрэгжүүлж байсныг Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулахаар өөрчилсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 100 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь, хандив тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, малын тоо толгойн албан татвар гэсэн 6 төрлийн эх үүсвэрээс бүрдэж байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай¹ хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 9,192.0 сая төгрөгөөр баталсан ба тус хуульд 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр орлогын шилжүүлгийн хэмжээг 449.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 9,641.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс урсгал зарлагад 962.4 сая төгрөгийг баталсан байна. Графикаар харуулбал: График-1



Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг 2022 оныг хүртэлх хугацаанд хэрэгжиж байна.

¹ 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан

“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 2021 онд 23 сумын ОНХС-д 202.4 сая төгрөгийн дэмжлэг, 650.8 сая төгрөгийн урамшуулал нийт 853.2 сая төгрөгийг олгосон байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд буюу 2020 оны 11 дүгээр сард хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитаар нийт 193.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг арилгах цаашид давтан гаргахгүй байх тухай зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

БҮЛЭГ 1:

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУМЫН ХӨГЖЛИЙН САНД
ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ АРГАЧЛАЛЫН ДАГУУ ҮНЭН ЗӨВ ТООЦОЖ
ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.**

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасан эх үүсвэрийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, сумын ОНХС-д олгох хөрөнгийг шилжүүлэг тооцох аргачлалын дагуу үнэн зөв тооцож, хуваарилаагүй байна.

Хөвсгөл аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг Сангийн яам 2020 онд 6,730.0 сая төгрөгөөр хуваарилж байсан бол 2021 онд 9,641.3 сая төгрөгөөр хуваарилсан байна. Өмнөх онтой харьцуулахад ОНХС-ийн эх үүсвэр 2,911.3 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хөвсгөл аймгийн 2021 оны ОНХС-д Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгээс 8,612.7 сая төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслийн дэмжлэг 202.4 сая төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслийн урамшуулал 650.8 сая төгрөг, АМХТЗТ 5.8 сая төгрөг, АМАТЗТ 62.2 сая төгрөг, АМНАТ 107.3 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 334.5 сая төгрөг, малын халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх үйлчилгээний төлбөрийн орлого 162.5 сая төгрөг, орон нутгийн давсан орлогоос 382.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 964.0 сая төгрөг нийт 11,456.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт-1		
д/д	Сумын нэр	Төлөвлөгөө /сая.төг/
1	Бүрэнтогтох	55.0
2	Рашаант	22.7
3	Тариалан	20.5
4	Төмөрбулаг	54.6
5	Ханх	8.0
6	Цагаан-Уул	80.0
7	Цагаан-Үүр	4.9
8	Цэцэрлэг	30.0
9	Шинэ-Идэр	38.8
10	Мөрөн	20.0
Нийт дүн		334.5

Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасны дагуу малын тоо толгойн албан татварын орлогыг 2021 онд Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоноос 10 сум 334.5 сая төгрөгийн орлогыг төлөвлөн гүйцэтгэлээр 23 сумын 1,129.9 сая төгрөгийн малын тоо толгойн татварын орлого бүрдүүлсэн байна. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд малын тоо толгойн албан татварын орлогыг бодитой төлөвлөөгүйгээс тайлант оны ОНХС-ийн эх үүсвэр 796.0 сая төгрөгөөр санхүүжигдэх боломж алдагдсан байна. Малын тоо толгойн албан татварыг төлөвлөсөн сумдыг хүснэгт 1-ээр харуулбал:

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолоор “Засаг дарга” дансанд Малын халдварт

өвчнөөс урьдчилан сэргийлэх 162.3 сая төгрөгийн орлогыг төлөвлөж гүйцэтгэлээр 225.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн эх үүсвэр болгон төвлөрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээ бүрдэнэ” заасан эх үүсвэртэй нийцэхгүйгээс гадна аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлж санхүүгийн тайлан үнэн зөв гарахад сөргөөр нөлөөлсөн байна.

Сангийн яам ОНХС-аас Хөвсгөл аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 2-12 дугаар саруудад батлагдсан хуваарь болон мөнгөн дүнгийн дагуу шилжүүлээгүй байна. Тухайлбал: Сангийн яамнаас 2 дугаар сард 408.0 сая төгрөг шилжүүлэхээр төлөвлөснөөс 203.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.4 “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд тооцож олгох орлогын шилжүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан сар, улирлын хуваарийн дагуу Төсвийн тухай хуулийн 56.3-т заасан нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд тухайн сарын төсвийн мэдээ гарсны дараа аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ” дэх заалттай нийцэхгүй байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцохдоо 87.2 сая төгрөгийн алдаатай тооцоолсноос тухайн сумын ОНХС-д олгох ёстой санхүүжилтийг сумдад 1.8-31.9 сая төгрөгөөр илүү, 0.2-17.9 сая төгрөгөөр дутуу олгосон байна. Хавсралт-1-ээр харуулав.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогыг алдаатай тооцоолсон нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

1. Орлогын шилжүүлгийг тооцоолоход ашигласан сумын хүн амын тоо аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан хүн амын албан ёсны тооноос зөрүүтэйгээс ОНХС-аас хүн амын тооноос хамаарч хуваарилахаар тооцсон дүн алдаатай илэрхийлэгдсэн байна. */17-1,366 хүний тоогоор зөрүүтэй тооцсон байна. /Хавсралт 2-оор харуулав./*
2. Санхүү төрийн сангийн хэлтсийн тооцсон сумаас аймаг хүртэлх алслалтын зай аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан зайнаас зөрүүтэй байгаа нь ОНХС-аас алслалтаас хамаарч, харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн алдаатай илэрхийлэгдсэн байна. */1-24 километрийн зөрүүтэй/*
3. ОНХС-ийн алслалтын индекс болон хүн амын тоонд жинлэсэн алслалтын индексийг мөн адил батлагдсан заавар аргачлалын дагуу тооцоогүй, алдаатай илэрхийлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын Найм “Аймаг, нийслэлийн хөгжлийн сангаас сум, дүүргийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцох зарчим”-дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх орлогыг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна. Тухайлбал: Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-ийн санд орлогыг шилжүүлэхдээ зарим саруудад аймгийн Засаг даргын баталсан сарын хуваарийн төлөвлөгөөнөөс дутуу эсвэл илүү олгосон байна. Мөн 7, 8, 9, 10 дугаар саруудад ОНХС-аас ирсэн санхүүжилтийг тус саруудад сумдын ОНХС-д хуваарилахгүйгээр 11, 12 дугаар сард олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.5² дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөс сумдын ОНХС-д санхүүжилтийг олгохдоо Төмөрбулаг суманд 61.8 сая төгрөгийг олгох байтал 56.8 сая төгрөгийг, Цагаан-Уул суманд 105.6 сая төгрөгийг олгох байтал 110.6 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгийг тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд олгоогүйг харуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг бүрэн төлөвлөөгүй, хуваарийн дагуу олгоогүй, орлогыг аргачлалын дагуу үнэн зөв тооцож хуваарилаагүй нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилаагүйг харуулж байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд: Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжин хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээнд 893.2 сая төгрөг, 2021 онд шинээр хэрэгжүүлэх 56 төсөл арга хэмжээнд 4,147.7 сая төгрөг, ОНХС-аас санхүүжих суурь зардалд 962.4 сая төгрөг нийт 6,003.3 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны 1 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний төсөвт 1,151.5 сая төгрөгийн нэмэх тодотгол хийсэн байна.

Аймгийн 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг эрэмбэлэх ажлын хэсгийг 2020 онд шинээр байгуулаагүй бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын 19-ний

² “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг ажлын 3 хоногийн дотор сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хуваарилна”

өдрийн А/580 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлж нэгтгэсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.7³ дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2015 оны 11 сарын 13-ны өдрийн “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” болон аймгийн ИТХ-ын Хуралдааны 2016 оны 9 сарын 24-ний өдрийн “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй нийцээгүй байна. Үүнд:

- ❖ "Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх /Соёл олон ястны өв/ хөтөлбөрийн Багц-3 -Нийтийн номын сан, орон нутаг судлах музейн байны цэвэр, бохир усны шугам сүлжээний шинэчлэл засвар хийх 18.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.
- ❖ "Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх /Соёл олон ястны өв/ хөтөлбөрийн хүрээнд аймгийн Хөгжимт драмын театрт 49.1 сая төгрөгийн дууны тоног төхөөрөмж авсан.
- ❖ Сумын соёлын төвүүдэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, үйл ажиллагаанд 28.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- ❖ “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд (зөв төлөвлөлт-өгөөжтэй эдийн засаг) багц-1 35.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг АЗДТГ болон ОНӨГ-т нийлүүлсэн байна.
- ❖ “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 19.1 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн.
- ❖ “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд Ахмад настны хөгжлийн төвийн цэвэр, бохир усны шугам засварын ажил гүйцэтгэх 14.8 сая төгрөгийн ажил
- ❖ "Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд /Аюулгүй орчин-Аз жаргалтай Мөрөн/ 17.0 сая төгрөгийн Зуухны мотор худалдан авах /Цагаан-Уул СӨБ/
- ❖ Багийн эмч нарыг унаажуулах мотоцикл худалдан авах ажлын санхүүжилт /Хариуцлагатай тогтвортой гэр бүл, Эрүүл монгол/

Аудитаар илэрсэн дээрх зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй. Аудитын хүрээнд хяналт хийгдсэн аймаг болон 12 сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн бүх төсөл, арга хэмжээнүүдийн зураг, төсөв, эдийн засгийн үндэслэл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн байна. Жишээ нь:

- ❖ "Хариуцлагатай тогтвортой гэр бүл" өрхийн хөгжлийн хөтөлбөр (Эрүүл монгол)
- ❖ "Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Соёл олон ястны өв)

³ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах;”

- ❖ "Оновчтой бодлого - Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд (Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг)
- ❖ "Оновчтой бодлого хариуцлагатай төсөв" - Тогтвортой үйлдвэрлэл-Байнгын ажлын байр
- ❖ "Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Цахим засаглал - 2024)
- ❖ Хамтын оролцоо -Хариуцлагатай засаглал -Утаагүй мөрөн
- ❖ "Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Хариуцлагатай нүүдэлчид)
- ❖ Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв /Хоггүй Хөвсгөл/- Сумын төвийн хог хаягдал зайлуулах ажил /Их-Уул, Ханх, Хатгал сум/ зэрэг төсөл арга хэмжээнүүдийн төсөв батлагдаж хэрэгжих шатанд аймгийн Засаг дарга захирамж гаргаж хэрэгжих ажлуудыг тодорхойлсон байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3⁴-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх,” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналд үндэслээгүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлагыг хангуулж ажиллаагүй байна гэж дүгнэлээ. **Сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд:** Аудитад хамрагдсан сумд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.8⁵-д заасан хугацаанд багтаан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-ний жагсаалтыг баг, хорооны ИНХ-аар хэлэлцэх, санал хураах хурлыг 5 дугаар сард багтаан зохион байгуулсан байна.

Сумдын ЗДТГ-ын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2⁶, 3.1.4⁷ дэх заалттай нийцэхгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-2

№	Сумын нэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/
1	Жаргалант сум	Ариутгалын бодис	1.7
2		Сумын онцгой комисст халдвар хамгааллын хэрэгсэл бэлтгэх	5.0
3		Ухаалаг худгийн төхөөрөмж	19.9
4		Халуун усны засвар	6.0
5	Тосонцэнгэл сум	Ерөнхий төлөвлөгөө сонинд нийтлэх	0.2
6		“Ногоон сум” хөтөлбөр	5.0
7		Гэрэлтүүлэг засвар	3.0
8		“Эрүүл-Тосонцэнгэл” хөтөлбөрийн хүрээнд “Шүд хөтөлбөр хэрэгжүүлэх	10.0
9	Шинэ-Идэр сум	Суваргатай уулын тохижилт	5.0
10	Чандмань-Өндөр	ЗДТГ-ын байрны зураг, төсөв	29.0
11		Бөхийн дэвжээ худалдан авах	3.6
Нийт дүн			88.4

⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

⁵ Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

⁶ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

⁷ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;”

Сумын ОНХС-ын хөрөнгөөр иргэдийн санлыг аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээ хэрэгжсэн нь сумын ИТХ-ын төлөөлөгчид иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг хуралдаанд саналаар оруулж баталдгаас шалтгаалж байна.

БҮЛЭГ 2:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө, үр дүн буурч байна.

2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сангийн зориулалтад нийцээгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-аас Хөвсгөл аймгийн 2021 оны төсвийг батлахдаа орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 56 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн төсөвт 2021 оны 8 дугаар сард тодотгол хийж 13 төсөл, арга хэмжээг хасаж 14 төсөл, арга хэмжээг нэмж баталсан бөгөөд үүгээр 2021 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 57 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тогтоожээ.

Батлагдсан 57 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээ, зураг төсөв боловсруулах 2 зөвлөх үйлчилгээ нийт 5 төсөл арга, хэмжээний эрхийг сумдад эрх шилжүүлж, 48 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан байна. Худалдан авах ажиллагаа явуулсан 48 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл, арга хэмжээг 55 багц болгон задалж нийт 93 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3			
д/д	Төсвийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Багцаар хуваасан тоо
1	2.2	"Хариуцлагатай тогтвортой гэр бүл" өрхийн хөгжлийн хөтөлбөр (Эрүүл монгол)	4
2	2.4	"Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Соёл-олон ястны өв)	6
3	2.5	"Оновчтой бодлого - Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд (Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг)	5
4	2.6	"Оновчтой бодлого хариуцлагатай төсөв" - Тогтвортой үйлдвэрлэл-Байнгын ажлын байр	7
5	2.7.5	Цагаан загас үржүүлэх нөхөн сэргээх туршилт судалгааны ажил / Цагааннуур сум/	2
6	2.12	Зураг төсвийн сан	19
7	2.15	"Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Цахим засаглал - 2024)	3
8	2.16	Хамтын оролцоо -Хариуцлагатай засаглал -Утаагүй мөрөн	3
9	2.18	"Хамтын оролцоо - Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Хариуцлагатай нүүдэлчид)	3
10	2.20.3	Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв /Хоггүй Хөвсгөл/- Сумын төвийн хог хаягдал зайлуулах ажил /Их-Уул, Ханх, Хатгал сум/	3
Нийт			55

Худалдан авах ажиллагаа явуулсан 93 төсөл, арга хэмжээнд баримталсан худалдан авах ажиллагааны журам үнийн санал авсан хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-4

д/д	Худалдааны авах ажиллагааны журам	Тоо
1	Нээлттэй тендер шалгаруулалт	27
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	-
3	Харьцуулалт арга	40
4	Шууд гэрээ байгуулах арга	12
5	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	14
6	Олон нийтийн оролцоотой ХАА-ны журам	-
Нийт		93

Тендерийг зарлаж үнийн санал авахдаа 81 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим, 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг уламжлалт цаасан хэлбэрээр зохион байгуулж ажилласан байна.

Аудитаар худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийн мөрдөлттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ "Хариуцлагатай тогтвортой гэр бүл" өрхийн хөгжлийн хөтөлбөр (Эрүүл монгол) төсөл, арга хэмжээний багц 2 - Сургалтын гарын авлага, багц 3.2 - шатахуун нийлүүлэх, "Оновчтой бодлого - Хариуцлагатай төсөв" дэд хөтөлбөрийн хүрээнд (Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг) төсөл, арга хэмжээний багц 5 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэгчийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, үнэлэх цогц систем гэсэн 3 төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчдийг шууд гэрээ байгуулах аргаар шалгаруулсан тухай мэдэгдлийг Сангийн яаманд хүргүүлээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.3⁸ заалттай нийцэхгүй байна.

Дээр дурдсан 3 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна. Гарсан зөрчлийн хэмжээ, нийт худалдан авах ажиллагааны байдлыг үндэслэн орон нутгийн хөгжлийн сангийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэлээ.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд 11,456.7 сая төгрөгийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн санд бүрдүүлж 7,172.7 сая төгрөгийг зарцуулан 4,284.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөвсгөл аймгийн 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 427 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталснаас 316 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт 427 төсөл, хөтөлбөр арга хэмжээний 294 төсөл, хөтөлбөр арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн, 22 төсөл арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн 110 төсөл арга хэмжээ нь огт хэрэгжээгүй байна.

Аудитаар аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ "Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв"/Зөв төлөвлөлт өгөөжтэй эдийн засаг/ дэд хөтөлбөрийн багц-2 Сургалтын үдийн цай, хоол нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сумдын санхүүгийн албаны дарга, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтын цай хоолны зардалд 4.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар 60.3-д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.3. *“үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал,”* дахь заалттай нийцэхгүй байна. Аудитаар илэрсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
- ❖ "Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв" /Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг/ дэд хөтөлбөрийн багц-4 "Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт" сургалт төсөл арга хэмжээний хүрээнд "Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв" ТББ-тай гэрээ байгуулж төрийн 42 албан хаагчийн худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтын төлбөр болох 3.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн боловч 33 албан хаагч сертификат олгох шалгалтад тэнцээгүй байна. Иймд шалгалтад тэнцээгүй 33 албан хаагчдын сургалтын төлбөр болох 2.6 сая төгрөгийг шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

⁸ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- ❖ Хүнсний ногооны зоорь барих /Хөвсгөл Галт сум/ 52.6 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ББКД-67-46/21 дугаар бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт үйлдэн, санхүүжилтийг бүрэн олгосон мөн Улсын комиссын актаар өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэгч компани болох “Хөвсгөл Хүрмэн” ХХК хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.12-т “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.” дахь заалттай нийцэхгүй байна. Аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
- ❖ “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” хөтөлбөрийн хүрээнд (Аюулгүй орчин-Аз жаргалтай мөрөн) Хөргүүртэй махны агуулах барих/Хөвсгөл Галт сум/ 99.2 сая төгрөгийн төсөвтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, зарим ажил зургийн дагуу хийгдээгүй байхад 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ББКД-67-71/21 дугаар бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарган, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.12-т “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.” дахь заалттай нийцэхгүй байна. Аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.
- ❖ “Хариуцлагатай тогтвортой гэр бүл” өрхийн хөгжлийн хөтөлбөр /Эрүүл-Монгол/ дэд хөтөлбөрийн хүрээнд мэргэжил дээшлүүлэх албан хаагчид дэмжлэг үзүүлэхэд 1.4 сая төгрөг, Мөрөн сумын иргэнд цусны хортой болон хоргүй хавдрын онош тодруулахад 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Баянзүрх сумын чихрийн шижин өвчинтэй иргэнд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын иргэн Н-д хагалгаанд ороход нь дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын 10 дугаар багийн иргэнд улаан хоолой залгах хагалгаанд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Тосонцэнгэл сумын 19 хоногтой нярайд цагаан мөгөөрсөн хоолойн нарийсалтын хагалгаанд 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын иргэн Т-д хиймэл нүд хийх хагалгааны зардалд 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын 13-р багийн иргэн 3-ийн уураг нөхөх эмчилгээний зардалд 1.0 сая төгрөгийн дэмжлэг нийт 5.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6 “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” дахь заалттай нийцэхгүй байна. Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гэрээнд барьцаа хөрөнгийг хуульд заасан хэмжээгээр тусгаж барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө нь буурч байна.

Аудитад хамрагдсан сумдад иргэдийн санал авч, эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүн, үр ашгийг багийн Засаг дарга нар Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу хүрэх үр дүн, төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцож төслийн танилцуулга бэлтгэн сумын Засаг даргад хүргүүлсэн байна. Харин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, үр ашгийг төлөвлөлтийн шатанд тооцож тодорхойлоогүй байна

ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний дийлэнх хэсгийг аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, аймаг сумдыг

гэрэлтүүлгийг сайжруулах болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс хөтөлбөрүүдийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2015 оны 11 сарын 13-ны өдрийн “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” болон аймгийн ИТХ-ын Хуралдааны 2016 оны 9 сарын 24-ний өдрийн “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй нийцүүлээгүйгээс гадна хүрэх түвшнийг тооцолгүй олон багцад жижиглэн зарцуулсан нь ОНХС-ийн хөрөнгийн үр дүн, үр ашгийг бууруулж байна.

2.3. Эрх бүхий байгууллагаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтад анхаарал хандуулаагүйгээс өмч, хөрөнгө эзэнгүйдсэн, үр ашгаа өгөөгүй байна.

Сангийн сайдын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцахаар заасан ч зарим байгууллагууд болон Орон нутгийн өмчийн газраас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016-2021 онд хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний үр дүн, ашиглалтыг авч үзлээ. Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ хэрэгжсэн цагаас эхлэн ашиглалтгүй, үр дүнгээ өгөөгүй байна. **Тухайлбал:** ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээ ашиглагдахгүй, үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна. Хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжсэн огноо	Төсөв /сая.төг/
1	Арбулаг	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех /Цагаан идээ боловсруулах/	2016	30.0
2	Арбулаг	Сумын төвийн худаг	2019	14.7
3	Галт	Тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	2013	29.8
4	Галт	Халуун усны барилга	2015	49.9
5	Галт	Мал угаалгын ванн рашаант баг	2017	5.9
6	Галт	Ахуйн үйлчилгээний барилга	2018	19.2
7	Галт	Хуурай сүүний үйлдвэрийн барилга	2018	35.5
8	Галт	Усан оргилуур	2019	16.9
9	Баянзүрх	Бяслагийн үйлдвэрийн байр	2020	28.0
10	Түнэл	Ахмадын өргөөний барилга	2020	50.0
11	Цагааннуур	Халуун усны барилга	2014	60.0
Нийт дүн				339.9

Дээрх хүснэгтээс харахад аймаг болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжил болон иргэдийг тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болоогүй, үр өгөөжөө өгч чадаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгийг өмчлөлд бүртгэж авсан зарим байгууллагуудын хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт сул байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хадгалалт, хамгаалалт хангалтгүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүснэгтээр харуулав. Хүснэгт -6

№	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжсэн огноо	Төсөв /сая.төг/	Тайлбар
1	Галт	Тэжээлийн үйлдвэрийн машин	2013	29.8	Авсан цагаас хойш огт ашиглаагүй бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим зөрчигдөн айлын хашаанд ил задгай байна.
2	Галт	Хуурай сүүний үйлдвэрийн барилга	2018	35.5	Хуурай сүүний үйлдвэр ажиллахаа больсон хариуцсан эзэн байхгүй.
3	Баянзүрх	Хогийн машин	2016	3.0	Эвдэрсэн
4	Баянзүрх	Алтрагийн голын гүүр	2021	3.5	Үерт урссан
5	Арбулаг	Буянтын булгийн эх хаших	2020	8.5	Хулгайд алдагдсан
6	Тариалан	Зарлан мэдээллийн систем	2017	6.9	Эвдэрсэн
7	Тариалан	Сэлэнгэ голын дээгүүр бярааз тавих	2017	15.0	Эвдэрсэн
8	Тариалан	Сэлэнгэ голын дээгүүр бярааз барих	2020	7.5	Эвдэрсэн
9	Цагааннуур	Стандарт тоглоомын талбай	2016	30.0	Тоглоомууд эвдэрсэн тул ажиллахгүй.
10	Цагааннуур	Хогны машин	2016	23.0	Эвдэрсэн
11	Цагааннуур	Сургууль, цэцэрлэгийн гал тогоо ЗДТГ-ын камержуулалт	2016	18.4	Аянга орж ажиллахгүй болсон
12	Цагааннуур	Интернэтийн тоног төхөөрөмж	2018	7.1	Аянга орж ажиллахгүй болсон
Нийт дүн				188.2	

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргад албан шаардлагаар хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

БҮЛЭГ 3:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авах боломжгүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

Сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод нь 23 сум, 1 тосгоноос 15 сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хяналтын үр дүнг тооцон ажиллаагүй, хэрэгжилтийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Сумдын ИТХ нь 2021 оны ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд 15 сум хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

⁹ Тухайн шатны ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

Дараах сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна. Үүнд:

1. Бүрэнтогтох сумын ИТХ
2. Жаргалант сумын ИТХ
3. Их-Уул сумын ИТХ
4. Рэнчинлхүмбэ сумын ИТХ
5. Тосонцэнгэл сумын ИТХ
6. Түнэл сумын ИТХ
7. Цагааннуур сумын ИТХ
8. Цагаан-Үүр сумын ИТХ

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁰, 2.8¹¹-д заасны дагуу аймгийн Засаг дарга “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй 271.9 сая төгрөгийн гэрээ байгуулан захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа нь нэг талаасаа мэргэжлийн инженерээр хяналт тавиулж барилгын чанар үр дүн сайжрах эерэг нөлөөтэй байна.

Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад хяналт хийх давтамж бага хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгахгүйгээс зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Тухайлбал:

1. **Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 52.6 сая төгрөгийн өртөгтэй Галт сумын Хүнсний ногооны зоорь:** Барилга байгууламжийн зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг /2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ББКД-67-46/21 дугаар/ гаргасан байна. Тус барилгын гүйцэтгэлийг хянахад дараах ажил хийгдээгүй байна. Үүнд:

- ❖ Дотор талын заслын ажил хийгдээгүй
- ❖ Төмс, хүнсний ногоо хадгалах ердийн зоорины орох хаалгыг МУ-ын MNS 3024:81 /стандартын дагуу баригдаж байгаа зоорины орох хаалгыг гадагш онгойдог болгох, дотор дулаан, сэрүүн нөхцөлийг хадгалах, агаар сэлгэх, халаах технологийг норм дүрэм стандартын дагуу хийгээгүй
- ❖ Орох хаалганы үүд хэсэгт хийсэн ус шингээх сувагт тор хийх ба багтаамжийг нэмэгдүүлээгүй.
- ❖ Хаяавчийг дахин сайжруулах шаардлагатай
- ❖ Хажуу талын баадан, цагаан таазны дулаалга дутуу /тааз хөөсөнцөр байхаар зурагт байхад хар цаас дэвсэж шланк буюу үнсээр хучсан/
- ❖ Шал резинин будгаар будаагүй

2. **Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 99.2 сая төгрөгийн өртөгтэй Галт сумын Хөргүүртэй махны агуулахын барилга угсралтын ажил:** Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ББКД-67-71/21 дүгээр шийдвэрээр хүлээн авч барилгыг бүрэн дууссан гэж үзсэн боловч бодит байдал дээр хяналт шалгалт хийхэд дараах ажлууд хийгдээгүй байна. Үүнд:
- ❖ Дотор талын ажил бүрэн хийгдээгүй /Сэндвич хавтан 100 мм зузаантай 133м2 талбайд дулаалга хийгдээгүй/

¹⁰ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹¹ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.(Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмсэн)

- ❖ Тус барилгад нэг бүр нь 15.0 сая төгрөгийн 2 хөргүүр суурилуулах ёстойгоос хийгдээгүй /Эзлэхүүн нь 100м³ халаах чадалтай, цахилгаан 8.8 кВт чадалтай/
- ❖ Гадна пандус 2 шат зургийн дагуу хийгээгүй
- ❖ Гадна фасад, цоклын хэсгийг өнгийг бүрэн шинэчлээгүй байна.
- ❖ Хаяавч хагарсан /дахин засварлах/
- ❖ Гадна цахилгааны шугам хийгээгүй. /техникийн нөхцөл авах/
- ❖ Газардуулгыг норм стандартын дагуу хийгээгүй /Газардуулгыг нормын дагуу хийж мэргэжлийн байгууллагаар шалгуулж акт, протоколоор баталгаажуулах/
- ❖ Дээврийн дотор таазны ажил дутуу /85.1 м² сэндвич хавтан, хөөсөнцөр дулаалгатай/
- ❖ Дотор цахилгааны тоноглолыг бүрэн дуусгаагүй /гэрэлтүүлэг, разетка хийх/
- ❖ Агааржуулалтын систем хийгдээгүй.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын зүгээс байнгын ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтэд тавих хяналт хангалтгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹², 46 дугаар зүйлийн 46.1.2¹³, 43.3¹⁴, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.2.2¹⁵-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчилд үндэслэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

“Барилга захиалагчийн хяналтын төв” нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс гадна санхүүжилтийн эрхийг нээж буй аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн холбогдох албан хаагчид гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжилтийг олгосноос дээрх зөрчлүүд үүссэн байна.

Аймгийн Засаг дарга нь зөвлөх үйлчилгээ үзүүлэгч буюу үе шатны хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй, тухайн жилд гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасан хугацаанд үнэлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 4 сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт шалгалт хийсэн байна. “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны эрсдэлд суурилсан хяналтын төлөвлөгөө”-нд аймгийн ОНХС-ын 2020, 2021 оны зарцуулалт болон 10 сумын ТАХ-ний 2019-2021 оны зарцуулалтад хяналт тавьж ажиллахаар төлөвлөсөн байна. Одоогийн байдлаар төлөвлөгөөнд заасан хугацаа болоогүй тул хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. ОНХС-ийн 2021 оны тайлан аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс нэгтгэгдэж аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргэгдээгүй байна.

Тогтвортой амьжиргаа–3 төслөөс хийсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт сумдын дундаж 63.4 хувиар, Хөвсгөл аймгийн хэмжээнд 65.1 хувиар тус тус үнэлэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь доогуур байгаа нь дараах сумдын үнэлгээ хангалтгүй байгаагаас шалтгаалжээ. Үүнд:

- | | |
|---------------------|--------------------|
| 1. Арбулаг-54% | 4. Тосонцэнгэл-55% |
| 2. Мөрөн-56% | 5. Ханх-54% |
| 3. Ренчинлхүмбэ-50% | 6. Цагааннуур-44% |

¹² Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна.

¹³ Энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

¹⁴ Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ.

¹⁵ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт” нийцлийн аудитаар ОНХС-ийн төлөвлөлт хяналт гүйцэтгэлтэй холбоотой 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан боловч 6 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Аймаг, сумын ИТХ-д өгсөн дараах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
 - ❖ Аймаг болон сумын ОНХС-ийн төлөвлөлт гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан, хяналтаар илэрсэн асуудлыг хэлэлцэж үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх.
2. ХБТХОХ-т өгсөн дараах 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
 - ❖ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргуулж ажиллаагүй.
 - ❖ ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй.
3. Сумын Засаг дарга нарт өгсөн дараах зөвлөмж хэрэгжээгүй байна.
 - ❖ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх.

3.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авах боломжгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.2¹⁶-д заасны дагуу сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэсэн боловч тус журмын 9.9¹⁷-д заасан шалгуурын дагуу тайланг гаргаагүй байна. Аудитаар тайлангийн гүйцэтгэлийн хянаж үзэхэд аймгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн дүнг нэгтгэсэн тайланд зөрүүтэй тайлагнасан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3¹⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Сумдын ОНХС-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаж тайлагнасан байна. Сумдын ОНХС-ийн тайланг тусад нь гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнасан байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авах боломжгүй байна.

ХБТХОХ нь ОНХС-ийн хөрөнгөөр батлагдсан төсвийг Удирдлагын мэдээллийн системд аймаг, сум тус бүрээр Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.2.2¹⁹ -д заасан хугацаанд үнэн зөв мэдээлээгүй байна.

¹⁶ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

¹⁷ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

¹⁸ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

¹⁹ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь орон нутгийн төсөв батлагдсаны дараа сум, дүүрэг тус бүрээр ОНХС-ийн батлагдсан төсвийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулна

Хөвсгөл аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9,192.1 сая төгрөгийн төсвөөс 8,838.3 сая төгрөгийн төсвийг мэдээлж 353.8 сая төгрөгийн төсвийн мэдээллийг мэдээлээгүй байна.

ХБТХОХ нь аймгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.3.2²⁰-д заасныг баримтлан үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна. Сумын ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд Мөрөн, Арбулаг, Жаргалант, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Ханх, Цэцэрлэг сумд мэдээлээгүй, бусад сумд зөрүүтэй мэдээлсэн байна.

Удирдлагын мэдээллийн системд ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зөрүүтэй мэдээлснийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-7

2021 оны ОНХС-ын хэрэгжилтийн тайлан (нэгдсэн) сая.төг				
№	Сумын нэр	Нийт хэрэгжилт	УМС-д мэдээлсэн	Зөрүү
1	Хөвсгөл аймаг	3926.7	1,906.6	2,020.1
2	Мөрөн сум	585.3	0.0	585.3
3	Алаг-Эрдэнэ сум	76.8	56.7	20.1
4	Арбулаг сум	87.3	0.0	87.3
5	Баянзүрх сум	92.9	64.8	28.1
6	Бүрэнтогтох сум	115.6	24.3	91.3
7	Галт сум	156.2	134.1	22.1
8	Жаргалант сум	145.7	0.0	145.7
9	Их-Уул сум	82.5	69.9	12.6
10	Рашаант сум	79.1	56.4	22.7
11	Ренчинлхүмбэ сум	203	0.0	203.0
12	Тариалан сум	382.8	127.8	255.0
13	Тосонцэнгэл сум	83.2	0.0	83.2
14	Төмөрбулаг сум	8.5	0.0	8.5
15	Түнэл сум	85.8	85.8	0.0
16	Улаан-Уул сум	150.1	8.7	141.5
17	Ханх сум	144.4	0.0	144.4
18	Цагааннуур сум	15.3	15.3	0.0
19	Цагаан-Уул сум	81.8	74.5	7.3
20	Цагаан-Үүр сум	137.6	75.9	61.7
21	Цэцэрлэг сум	120.6	0.0	120.6
22	Чандмань-Өндөр сум	144.4	155.3	-10.9
23	Шинэ-Идэр сум	57.6	53.4	4.2
24	Эрдэнэбулган сум	174.3	174.3	0.0
25	Хатгал сум	35.2	35.2	0.0
	Нийт	7172.7	3,118.9	4,053.8

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг ТЕЗ болон 22 сум, 1 тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч олон нийтэд ил, тод үнэн зөв мэдээлсэн бөгөөд Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагч 2021 оны ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Аудитаар нийт 1,847.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 2.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 960.0 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 884.4 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

²⁰ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд оруулна

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу үнэн зөв тооцож хуваарилаагүй байна.
2. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн саналд үндэслээгүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сангийн зориулалтад нийцээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө нь буурч байна.
5. Эрх бүхий байгууллагаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтад анхаарал хандуулаагүйгээс зарим өмч, хөрөнгө эзэнгүйдсэн, үр ашгаа өгөөгүй байна.
6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт хангалтгүй байна.
7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авах боломжгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан, хяналтаар илэрсэн асуудлыг хэлэлцэж үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх
2. Иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сангийн зориулалтад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшнийг тодорхойлж, үр дүнг тооцож ажиллах.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбатад:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн саналд үндэслэн, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж байх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшин үр дүнг тооцож ажиллах.

Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсорогдогт:

1. Худалдан авах ажиллагааны үр дүнд шууд гэрээ байгуулах аргыг сонгон гэрээ байгуулсан тухай бүр Сангийн яаманд энэ тухай мэдэгдэж ажиллах
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллах

Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базарт:

1. Хөвсгөл аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-ийн орлогыг шилжүүлэхдээ аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлэх
2. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-ийн санхүүжилтийг олгохдоо тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд олгох.
3. ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасны дагуу бүрэн төлөвлөж, бүрдүүлэх

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтуяад:

1. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрэх түвшнийг төлөвлөлтийн шатанд тооцож ажиллах.
2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, иж бүрэн мэдээлэх.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тайланг нэгтгэн журмын дагуу үнэн зөв тайлагнах

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Б.Янжиндолгорт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлэх

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах
2. Сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийх хяналтыг чанартай хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах

Сумдын Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх
2. ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, иж бүрэн мэдээлэх.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллах

Зөрчлийн нэгтгэл:

/Сая.төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцоходоо 85.3 сая төгрөгийн алдаатай тооцоолсноос тухайн сумын ОНХС-д олгох ёстой санхүүжилтийг сумдад 0.2-31.4 сая төгрөгөөр илүү, 0.2-18.7 сая төгрөгөөр дутуу олгосон байна.	87.2			1	87.2		
2	Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх орлогыг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.	-					1	-
3	Малын тоо толгойн татварыг 14 суманд ОНХС-ийн эх үүсвэрт нэмж төлөвлөөгүй байна.	796.0					1	796.0
4	Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолоор “Засаг дарга” ерөнхий дансанд Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 162.3 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн байхад аймгийн ОНХС-ийн эх үүсвэр болгон 225.0 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлэн зарцуулсан байна.	-					1	
5	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлээгүй байна.						1	
6	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.	-			1	-		
7	Зарим сумдад иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	88.4					1	88.4
8	Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй нийцээгүй төсөл, арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн байна.	182.9			1	182.9		
9	Төсөл, арга хэмжээнд зураг, төсөв, эдийн засгийн үндэслэлгүй төсөл, арга хэмжээ төлөвлөн батлуулж байна.	-					1	-
10	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчдийг шууд гэрээ байгуулах аргаар шалгаруулсан тухай мэдэгдлийг Сангийн яаманд мэдээлээгүй байна.	-					1	-
11	“Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв”/Зөв төлөвлөлт өгөөжтэй эдийн засаг/ дэд хөтөлбөрийн багц-2 Сургалтын үдийн цай, хоол нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Хөвсгөл Өргөө ХХК-тай гэрээ байгуулж Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сумдын санхүүгийн албаны дарга, төсвийн	4.6			1	4.6		

	байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтын цай хоолны зардалд 4.6 сая төгрөгийг зарцуулсан байна.						
12	“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” /Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг/ дэд хөтөлбөрийн багц-4 “Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт” сургалт төсөл арга хэмжээний хүрээнд “Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв”ТББ-тай гэрээ байгуулж төрийн 42 албан хаагчийн худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтын төлбөр болох 3.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн боловч 33 албан хаагч сертификат олгох шалгалтад тэнцээгүй байна.	2.6	1	2.6			
13	Хүнсний ногооны зоорь барих /Хөвсгөл Галт сум/ 52.6 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ББКД-67-46/21 дугаар бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт үйлдэн, санхүүжилтийг бүрэн олгосон мөн Улсын комиссын актаар өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэгч компани буюу “Хөвсгөл Хүрмэн” ХХК хэрэгжүүлээгүй байна.				1	151.8	
14	“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” хөтөлбөрийн хүрээнд (Аюулгүй орчин-Аз жаргалтай мөрөн) Хөргүүртэй махны агуулах барих/Хөвсгөл Галт сум/ 99.2 сая төгрөгийн төсөвтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, зарим ажил зургийн дагуу хийгдээгүй байхад 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ББКД-67-71/21 дугаар бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарган, санхүүжилтийг бүрэн олгосон байна.	151.8					
15	“Хариуцлагатай тогтвортой гэр бүл” өрхийн хөгжлийн хөтөлбөр /Эрүүл-Монгол/ дэд хөтөлбөрийн хүрээнд мэргэжил дээшлүүлэх албан хаагчид дэмжлэг үзүүлэхэд 1.4 сая төгрөг, Мөрөн сумын иргэнд цусны хортой болон хоргүй хавдрын онош тодруулахад 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Баянзүрх сумын чихрийн шижин өвчинтэй иргэнд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын иргэн Н-д хагалгаанд ороход нь дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын 10 дугаар багийн иргэнд улаан хоолой залгах хагалгаанд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Тосонцэнгэл сумын 19 хоногтой нярайд цагаан мөгөөрсөн хоолойн нарийсалтын хагалгаанд 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын иргэн Т-д хиймэл нүд хийх хагалгааны зардалд 0.5 сая төгрөгийн дэмжлэг, Мөрөн сумын 13-р багийн иргэн 3-ийн уураг нөхөх эмчилгээний зардалд 1.0 сая төгрөгийн дэмжлэг нийт 5.4 сая төгрөгийг зарцуулсан байна.	5.4			1	5.4	
16	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, үр ашгийг төлөвлөлтийн шатанд тооцож тодорхойлоогүй байна	-					1
17	Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ хэрэгжсэн цагаас эхлэн ашиглалтгүй, үр дүнгээ өгөөгүй байна	339.9			1	339.9	
18	Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.	188.2				188.2	

19	Зарим сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.	-					2	-
20	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэсэн боловч дээд шатны байгууллагад хүргүүлээгүй байна.	-					1	-
21	Нэгтгэсэн тайланд аймгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн дүнг зөрүүтэй тайлагнасан байна.	-					1	-
22	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь ОНХС-ийн журмын 9.3 -т заасны дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.	-					1	-
23	ОНХС-ийн хөрөнгөөр батлагдсан төсвийг Удирдлагын мэдээллийн системд аймаг, сум тус бүрээр Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.2.2 -д заасан хугацаанд үнэн зөв мэдээлээгүй байна.	-					2	-
24	ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.3.2 -д заасны дагуу бүрэн мэдээлээгүй байна.	-					2	-
НИЙТ ДҮН		1,847.0	1	2.6	7	960.0	18	884.4

АЙМГИЙН ОНХС-ААС СУМЫН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН ТООЦООЛОЛ

Хавсралт-1

№	Сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын тоо	Аймаг хүртэлх зай	Алслалтын индекс	Хүн амын тоонд жинтэсэн алслалтын индекс	Итгэлцүүрийн хуваарилалт						
							Алслалтаас хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Нутаг дэсвгэрээс хамаарах хуваарилалт 30%	Итгэлцүүрээр хуваарилагдсан нийт дүн	СТСХ-ийн тооцоолсноор Суманд шилжүүлсэн нийт дүн	Аудит тооцсон Суманд шилжүүлэх дүн	Тооцооллын зөрүү
1	Алаг-Эрдэнэ сум	4.50	3,325	62.7	0.223929	744.6	36,673.9	75,753.4	101,792.3	214,219.7	88,278.1	91,361.0	(3,082.9)
2	Арбулаг сум	3.53	4,032	79.2	0.282857	1,140.5	56,175.0	91,861.0	79,780.1	227,816.1	95,129.7	97,115.9	(1,986.1)
3	Хатгал	0.90	3,418	98	0.350000	1,196.3	58,924.5	77,872.3	20,345.1	157,141.8	62,246.5	60,470.2	1,776.3
4	Баянзүрх сум	4.30	3,983	131	0.467857	1,863.5	91,786.6	90,744.6	97,184.9	279,716.1	90,056.1	91,292.3	(1,236.1)
5	Бүрэнгогтох сум	3.77	4,405	51.4	0.183571	808.6	39,829.7	100,359.1	85,191.7	225,380.4	107,527.4	108,773.5	(1,246.1)
6	Галт сум	3.60	5,430	161	0.575000	3,122.3	153,788.3	123,711.6	81,308.7	358,808.6	144,250.0	155,210.1	(10,960.1)
7	Жаргалант сум	2.55	5,548	185	0.660714	3,665.6	180,553.5	126,400.0	57,627.0	364,580.5	136,696.2	154,342.2	(17,646.0)
8	Их-Уул сум	2.02	4,110	112.7	0.402500	1,654.3	81,482.3	93,638.1	45,749.8	220,870.2	99,291.2	100,539.1	(1,248.0)
9	Рашаант сум	1.98	3,794	136	0.485714	1,842.8	90,768.2	86,438.7	44,816.2	222,023.1	100,839.6	96,700.2	4,139.4
10	Рэнчинлхүмбэ сум	8.45	4,863	226	0.807143	3,925.1	193,335.0	110,793.7	190,980.2	495,108.9	155,262.6	162,246.9	(6,984.4)
11	Тариалан сум	3.43	6,209	157	0.560714	3,481.5	171,482.2	141,459.6	77,552.5	390,494.3	149,949.0	167,872.2	(17,923.2)
12	Тосонцрэнгэл сум	2.04	4,451	64	0.228571	1,017.4	50,111.2	101,407.1	46,165.9	197,684.3	82,518.6	84,485.2	(1,966.6)
13	Төмөрбулаг сум	2.52	4,315	73.3	0.261786	1,129.6	55,639.4	98,308.6	57,005.1	210,953.1	89,341.2	90,854.1	(1,512.8)
14	Түнэл сум	3.58	4,323	52.9	0.188929	816.7	40,228.9	98,490.9	80,867.9	219,587.7	92,025.0	94,686.2	(2,661.2)
15	Улаан-Уул сум	10.06	4,242	165	0.589286	2,499.8	123,126.7	96,645.4	227,356.8	447,128.9	192,815.1	193,345.9	(530.9)
16	Ханх сум	5.50	2,818	280	1.000000	2,818.0	138,802.3	64,202.5	124,301.9	327,306.7	156,445.7	140,114.3	16,331.4
17	Цагаан-Уул сум	5.87	5,699	131	0.467857	2,666.3	131,331.1	129,840.2	132,611.8	393,783.1	174,860.7	187,430.4	(12,569.7)
18	Цагааннуур сум	5.41	1,979	257	0.917857	1,816.4	89,469.8	45,087.5	122,258.1	256,815.5	133,071.5	101,116.6	31,954.9
19	Цагаан-Үүр сум	8.74	2,671	176	0.628571	1,678.9	82,695.9	60,853.4	197,467.8	341,017.1	121,568.2	111,296.1	10,272.1
20	Цэцэрлэг сум	7.45	4,658	199	0.710714	3,310.5	163,061.0	106,123.2	168,448.7	437,632.9	314,870.2	320,329.2	(5,459.0)
21	Чандмань-Өндөр сум	4.49	3,073	139	0.496429	1,525.5	75,140.7	70,012.1	101,443.8	246,596.6	111,512.6	105,789.5	5,723.1
22	Шинэ-Идэр сум	2.05	3,185	132	0.471429	1,501.5	73,957.3	72,563.8	46,422.1	192,943.2	87,324.6	83,945.7	3,378.8
23	Эрдэнэбулган сум	4.69	3,017	220	0.785714	2,370.5	116,760.4	68,736.3	106,119.5	291,616.2	139,876.6	126,206.4	13,670.2
24	Мөрөн сум	0.10	40,770		0.000000	-	-	928,862.4	2,326.1	931,188.6	397,884.5	398,117.5	(233.1)
		101.5	134.3			46,596.2	2,295,124.1	3,060,165.4	2,295,124.1	7,650,413.5	3,323,640.8	3,323,640.7	

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОНХС-ААС СУМДЫН ОНХС-Д ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН ТООЦООЛОЛД АШИГЛАСАН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗӨРҮҮ

Хавсралт-2

№	Аймаг	Сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын тоо	Статистик ийн хэлтсээс гаргасан хүн амын тоо	Зөрүү	СТСХ-ийн тооцсон алсалтын хэмжээ /километр/	Статистикийн хэлтсээс гаргасан алсалтын хэмжээ /километр/	Зөрүү
1	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ сум	4.50	6,526	6,743	217.0	65	62.7	2.3
2	Хөвсгөл	Арбулаг сум	3.53	4,000	4,032	32.0	71	79.2	-8.2
3	Хөвсгөл	Баянзүрх сум	4.30	4,008	3,983	(25.0)	127	131	-4
4	Хөвсгөл	Бүрэнгогтох сум	3.77	4,453	4,405	(48.0)	51	51.4	-0.4
5	Хөвсгөл	Галт сум	3.60	5,494	5,430	(64.0)	168	161	7
6	Хөвсгөл	Жаргалант сум	2.55	5,319	5,548	229.0	182	185	-3
7	Хөвсгөл	Их-Уул сум	2.02	4,129	4,110	(19.0)	112	112.7	-0.7
8	Хөвсгөл	Рашаант сум	1.98	3,740	3,794	54.0	157	136	21
9	Хөвсгөл	Рэнчинлхүмбэ сум	8.45	4,907	4,863	(44.0)	250	226	24
10	Хөвсгөл	Тариалан сум	3.43	6,096	6,209	113.0	165	157	8
11	Хөвсгөл	Тосонцэнгэл сум	2.04	4,344	4,451	107.0	64	64	0
12	Хөвсгөл	Төмөрбулаг сум	2.52	4,367	4,315	(52.0)	73	73.3	-0.3
13	Хөвсгөл	Түнэл сум	3.58	4,214	4,323	109.0	46	52.9	-6.9
14	Хөвсгөл	Улаан-Уул сум	10.06	4,259	4,242	(17.0)	178	165	13
15	Хөвсгөл	Ханх сум	5.50	2,783	2,818	35.0	281	280	1
16	Хөвсгөл	Цагаан-Уул сум	5.87	5,641	5,699	58.0	140	131	9
17	Хөвсгөл	Цагааннуур сум	5.41	1,950	1,979	29.0	272	257	15
18	Хөвсгөл	Цагаан-Үүр сум	8.74	2,650	2,671	21.0	173	176	-3
19	Хөвсгөл	Цэцэрлэг сум	7.45	4,538	4,658	120.0	209	199	10
20	Хөвсгөл	Чандмань-Өндөр сум	4.49	3,058	3,073	15.0	139	139	0
21	Хөвсгөл	Шинэ-Идэр сум	2.05	3,278	3,185	(93.0)	140	132	8
22	Хөвсгөл	Эрдэнэбулган сум	4.69	2,988	3,017	29.0	240	220	20
23	Хөвсгөл	Мөрөн сум	0.10	39,404	40,770	1,366.0	-	-	0
			100.6	132.1	132.1	132.1			0

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



Санал
ирүүлээгүй
болно.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/409 дүгээр албан бичгээр өгсөн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Р.МАШБАТ

67120007216



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 87120
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2022.06.06 № 8/1246
Танай _____ -нхь № _____ -т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд холбогдох тайлбарыг хүргэв.

Хавсралт ... хуудастай

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Т.БАЗАР

671700144

Санал
ирүүлээгүй
болно.


Хавсралт

Зөрчлийн нэгтгэл:

№	Илэрсэн зөрчлийн утга	Мөнгөн дүн (сая.төгрөг)	Санхүү, төрийн сангийн хэлтсийн хариу тайлбар
A	2	3	4
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцохдоо 85,3 сая төгрөгийн алдаатай тооцоолсноос тухайн сумын ОНХС-д олгох ёстой санхүүжилтийг сумдад 0.2-31.4 сая төгрөгөөр илүү, 0.2-18.7 сая төгрөгөөр дутуу олгосон байна.	85.3	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад холбогдох тайлбарыг дэлгэрэнгүй хүргэсэн болно. Цаашид орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо хүн амын мэдээллийг аймгийн статистикийн хэлтсээс, аймгийн төвөөс сум хүртэлх алслалтыг аймгийн Авто тээврийн төвөөс баталсан хэмжээг мөрдөн ажиллах болно. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.
2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д шилжүүлэх орлогыг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.		Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.
3	Малын тоо толгойн татварыг 14 суманд ОНХС-ийн эх үүсвэрт нэмж төлөвлөөгүй байна.		Ковид-19 цар тахал нь тус орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, эх үүсвэрийн хуваарилалтад сөргөөр нөлөөлсөн.
4	Аймгийн ИТХ-ын 2020.12.03-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолоор “Засаг дарга” ерөнхий дансанд Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 162,3 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн байхад аймгийн ОНХС-ийн эх үүсвэр болгон 225.0 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлэн зарцуулсан байна.		2021 оны төсөв батлагдахдаа “Засаг дарга” ерөнхий дансанд Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 162,3 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн боловч төлөвлөгөө нь төсвийн төлөвлөлт хуваарилалтын “Fiscal” праграмм дээр Засаг дарга дансан дээр биш ОНХС-ийн дансан дээр нээгдсэн тул аймгийн ОНХС-ийн эх үүсвэр болгон 225.0 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлэн зарцуулсан байна. 2022 оны төсөв дээр холбогдох газарт хүсэлт хүргүүлэн залруулах арга хэмжээг авсан болно.

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн

Хэлтсийн дарга

 /Г.Базар/

Ахлах мэргэжилтэн



/Х.Энхтүяа/



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

АЗИТГ-ын байр: Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001

Цахим шуудан: hovsgol.zdtg@khsg.gov.mn

Цахим хуудас: www.hovsgol.gov.mn


Хол. 06 00 № 2/1243

Төмөр _____ -ийг нэ _____ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд санал хүргүүлэв.

ОРЛОГЧ



М.ХҮЯГБААТАР

671207001



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг 57120
Утас: 7030 3303, Цахим шуудан: tuvsqulzdtg@xho.gov.mn
Цахим хуудас: www.xhovsgol.gov.mn

2022.06.06 № 6/1244
Тамга _____ -нө № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд санал хүргүүлэв.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНТУЯА



671703144

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн санал

Аудитын нэр: “Орон нутгийн хөгжлийн сангийн
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”

Аудитын код: ХӨА-2022/30-20-ШТА-ГА

Байгууллагын нэр: Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая.төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
A	2	3	4	5	6
1	Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд гүйцэтгэх Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулсан баримтууд болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдах төсөл, арга хэмжээг эрэмбэлж нэгтгэсэн тайлан, холбогдох баримт материал байхгүй байна.		Албан шаардлага өгөх	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг авч, саналыг нэгтгэсэн бөгөөд ажлын хэсэг байгуулж, эрэмбэлж ажилласан. Холбогдох баримтыг дахин хүргүүлэв. Архивын холбогдох 29 нэгж баримтыг өмнө хүргүүлсэн бөгөөд дахин хүргүүлж байна. Хасуулах саналтай байна.	Хасуулах саналтай байна.
2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг авсан боловч ажлын хэсэг байгуулж, эрэмбэлж ажиллаагүй байна.				
3	“Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй нийцээгүй төсөл, арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн байна.	182,9	Албан шаардлага өгөх	“Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний 2.9.3-ийн 177-д Нийтийн номын сан, Орон нутаг судлах музейн байрны цэвэр бохир усны шугам сүлжээний шинэчлэл, засвар хийх, 178-д Сумын соёлын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, урамшуулах гэсэн заалттай “Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал” дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх /Соёл олон ястны өв/ хөтөлбөрийн Багц-3, “Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал” дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх /Соёл олон ястны өв/ хөтөлбөрийн хүрээнд аймгийн Хөгжимт драмын театрт 49.1 сая төгрөгийн дууны тоног төхөөрөмж худалдан авах, Сумын соёлын төвүүдэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүд нь нийцэж байгаа тул албан шаардлагаас хасуулах саналтай байна. “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний 4.2.16 Төрийн албан хаагчдийг тоног төхөөрөмжийг шинэчлэх гэсэн заалттай нийцэж байгаа тул “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд (эв төлөвлөлт-өгөөжтэй эдийн засаг) багц-1 35.7 сая	Хасуулах саналтай байна.

Холбогдох байгууллагын саналд өгөх хариу тайлбар:

Санал – 1. Саналыг хүлээн авч зөрчлөөс хасав.

Санал -2. Саналыг хүлээн авч зөрчлөөс хасав.

Санал – 3. Саналыг хүлээн авах боломжгүй байна.

				төгрөгийн тоног төхөөрөмжийг АЗДТГ болон ОНӨГ-т нийлүүлсэнг хасуулах саналтай байна. Мөн “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний 4.2.16 Төрийн албан хаагчдийг тоног төхөөрөмжийг шинэчлэх гэсэн заалттай нийцэж байгаа тул “Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд (зөв төлөвлөлт-өгөөжтэй эдийн засаг) багц-1 35.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг АЗДТГ болон ОНӨГ-т нийлүүлсэнг хасуулах саналтай байна. ЗДҮАХ-ийн 2.1.6 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна. Гэсэн заалтын 30-д Зорилтот бүлгийн эх хүүхдэд гуравдагч шатлалын эмнэлэгт үзүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Мөн 2.1.3 22-д Сумдын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж чадавжуулах гэсэн заалттай1. “Хариуцлагатай тогтвортой гэр бүл” өрхийн хөгжлийн хөтөлбөр /Эрүүл-Монгол/ дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон сургалтын төлбөр, тусламж, санхүүгийн дэмжлэгүүд нийцэж байгаа тул хасуулах саналтай байна.	
4	“Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд /Зөв төлөвлөлт өгөөжтэй эдийн засаг/ “Сургалтын үдийн цай, хоол нийлүүлэх/ Хөвсгөл Өргөө ХХК-тай гэрээ байгуулж аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сумдын санхүүгийн албаны дарга, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтын цай хоолны зардалд 4.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Ажлын тайлангаас харахад Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан сургалт явуулсан байна.	4.6	Төлбөрийн акт тогтоох	Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын санхүүгийн албаны дарга, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтыг зохион байгуулсан. Үг арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 4.2.1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац шинжлэх ухаан, цахим технологи; гэсэн заалтын дагуу боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, Төсвийн тухай хуулийн 60.4.Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй гэсэн заалтын дагуу Санхүү, төрийн сангийн хэлтэс нь өөрийн чиг үүрэг, удирдлагыг хэрэгжүүлж, сургалтыг зохион байгуулсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн журам болон Төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн албан хаагчдыг зайлшгүй чадавжуулах шаардлага, сургалтыг зохион байгуулах нөхцөл байдалд бий болсоны үндсэн дээр журам, хуулийг зөрчилгүй удирдлагыг хэрэгжүүлэх	Хасуулах саналтай байна.

Санал -4. Саналыг
хүлээн авч албан
шаардлага өгөхөөр
шийдвэрлэв.

				чиг үүргийг хэрэгжүүлсэн болно. Иймд төлбөрийн актыг хасуулах саналтай байна.	
5	“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд /зөв төлөвлөлт, өгөөжтэй адийн засаг, Хөвсгөл мөрөн сум/ худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд 42 албан хаагчийн АЗ сертификатын сургалтын төлбөр болох 3.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийг төлсөн. Сургалтад тэнцээгүй 33 албан хаагчдын төлбөр болох 2.6 сая төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.	2.6	Аудитаар төлбөрийн акт тогтоох	“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” дэд хөтөлбөрийн хүрээнд /зөв төлөвлөлт, өгөөжтэй адийн засаг, Хөвсгөл мөрөн сум/ худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд АЗ сертификатын сургалтыг “Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв” ТББ-тай гэрээ байгуулан сургалтыг зохион байгуулсан. Уг гэрээгээр сургалтыг л зохион байгуулах гэрээ байгуулсан бөгөөд бүх албан хаагчдийг тэнцүүлэх гэсэн утгатай гэрээ байгуулаагүй бөгөөд сургалтын байгууллага сургалтыг л зохион байгуулах л үүргийг хүлээсэн болно. Иймд сургалтад хамрагдаж тэнцээгүй 33 албан хаагчдын төлбөр болох 2.6 сая төгрөгийг сургалт зохион байгуулсан төрийн бус байгууллага буцаан төлөх боломжгүй тул төлбөрийн актаас хасуулах саналтай байна.	Хасуулах саналтай байна.
6	Хүнсний ногооны зоорь барих /Хөвсгөл Галт сум/ 52.6 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуу байхад 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ББКД-67-46/21 дугаар бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт үйлдэн, санхүүжилтийг бүрэн олгосон. Улсын комиссын актаар өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэгч компани буюу “Хөвсгөл Хүрмэн” ХХК хэрэгжүүлээгүй байна.	151.8	Албан шаардлага өгөх	Хүнсний ногооны зоорь барих /Хөвсгөл Галт сум/ 52.6 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээг гүйцэтгэсэн Хөвсгөл хүрмэн ХХК нь улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн тухай албан бичиг фото зургийг ирүүлсэн тул хасуулах саналтай байна. Хэсрэлтээр албан бичиг, фото зургийг хавсаргав.	Хасуулах саналтай байна.
7	“Хариуцлагатай тогтвортой гэр бүл” өрхийн хөгжлийн хөтөлбөр /Эрүүл-Монгол/ дэд хөтөлбөрийн хүрээнд Мэргэжил дээшлүүлэх албан хаагчид дэмжлэг үзүүлж 1.4 сая төгрөгийн сургалтын төлбөр төлсөн. Мөрөн сумын иргэнд цусны хортой болон хоргүй хавдрын онош тодруулахад 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Баянзүрх сумын чихрийн шижин өвчинтэй иргэнд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөрөн сумын иргэн Н-д хагалгаанд ороход нь дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөрөн сумын 10 дугаар багийн иргэнд улаан хоолой залгах хагалгаанд дэмжлэг үзүүлж 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тосонцэнгэл сумын 19 хоногтой нярайд цагаан мөгөөрсөн хоолойн нарийсалтын хагалгаанд 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөрөн сумын иргэн Т-д хиймэл нүд хийх хагалгааны зардалд 0.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөрөн сумын 13-р багийн иргэн З-ийн уураг нөхөх эмчилгээний зардалд 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 5.4 сая төгрөг.	5.4	Албан шаардлага өгөх	ЗДҮАХ-ийн 2.1.6 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдалд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдал, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна. Гэсэн заалтын 30-д Зорилтот бүлгийн эх хүүхдэд гуравдагч шатлалын эмнэлэгт үзүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Мөн 2.1.3 22-д Сумдын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж чадаажуулах гэсэн заалттай “Хариуцлагатай тогтвортой гэр бүл” өрхийн хөгжлийн хөтөлбөр /Эрүүл-Монгол/ дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон сургалтын төлбөр, тусламж, санхүүгийн дэмжлэгүүд нийцэж байгаа тул хасуулах саналтай байна.	Хасуулах саналтай байна.
8	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь ОНХС-ийн хөрөнгөөр батлагдсан төслийг Удирдлагын мэдээллийн системд аймаг, сум тус бүрээр журмд заасан		Зөвлөмж өгөх	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны	Хасуулах саналтай байна.

Санал – 5. Саналыг хүлээн авах боломжгүй болно.

Санал – 6. Саналыг хүлээн авах боломжгүй болно.

Санал – 7. Саналыг хүлээн авах боломжгүй болно.

хугацаанд үнэн зөв мэдээлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10.2.2 “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлийн хэлтэс нь орон нутгийн төсөв батлагдсаны дараа сум, дүүрэг тус бүрээр ОНХС-ийн батлагдсан төсвийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулаа” гэсэн заалттай нийцэхгүй байна	ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна” гэсэн журмын заалттай учир Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь Удирдлагын мэдээллийн системд сумдын мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор оруулахгүй болсон. Мөн Сангийн сайдын 228 дугаар журам нь 2021 оны 06 дугаар сард хүчингүй болсон тул үүнийг хэсүүлэх саналтай байна
--	--

Танилцсан:

Аймгийн Засаг даргын орлогч

Хянасан:

ХБТХО-ын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Бичсэн:

ХБТХО-ын хэлтсийн ахлах мэргэжилтэн:

М.Хуягбаатар/
Б.Оюунтуяа/
Л.Занданмядагсүрэн/

Санал – 8. Саналыг хүлээн авах боломжгүй болно.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 12/А2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” /Зөв төлөвлөлт, өгөөжтэй эдийн засаг/ дэд хөтөлбөрийн хүрээнд иргэдийн санал авч, эрэмбэлэгдээгүй “Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, сургалт” төсөл, арга хэмжээг “Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв” ТББ-тай 3,360,000/гурван сая гурван зуун жаран мянга/ төгрөгийн гэрээ байгуулж төрийн 42 албан хаагчийн А3 сертификатын сургалтын төлбөрийг төлсөн байна. Худалдан авах ажиллагааны А3 сертификатын сургалтын төлбөрийг төлсөн 42 албан хаагчаас 33 албан хаагч А3 сертификат олгох шалгалтад тэнцээгүйгээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болох 2,640,000/хоёр сая зургаан зуун дөчин мянга/ төгрөг үр ашиггүй зарцуулагдсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.” Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7-д “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй.” 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. А3 сертификатын шалгалтад тэнцээгүй 33 албан хаагчийн сургалтын төлбөрийн зардал 2,640,000/хоёр сая зургаан зуун дөчин мянга/ төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т нотлох баримтын хамт ирүүлэхийг Засаг дарга

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

Ш.Идэрбаясгалан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар нарт хариуцуулав.



ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 60/А2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хариуцлагатай тогтвортой гэр б/л” /Эрүүл-Монгол/ өрхийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нэр бүхий 8 иргэнд 5,400,000/таван сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7-д “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй:” 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэнд буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 сарын 6 өдөр

№ 61/А2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Оновчтой бодлого-Хариуцлагатай төсөв”/Зөв төлөвлөлт өгөөжтэй эдийн засаг/ хөтөлбөрийн “Сургалтын үдийн цай, хоол нийлүүлэх” төсөл, арга хэмжээний хүрээнд Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан сумдын санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтын цай, хоолны зардалд 4,640,000/дөрвөн сая зургаан зуун дөчин мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:” 60.3.3-д “үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс ойн арга хэмжээнд зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 62/А.2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг “Ажлын хэсэг”-ээр гаргуулж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.7-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах,” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8, 4.2.1.10-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгээр төсөл, арга хэмжээний төсөвт нөлөөлөх нөлөөлөл, урсгал зардлын талаар дүгнэлт гаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөзсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 63/А.2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцохдоо 87,246,200.0 (наян долоон хоёр зуун дөчин зургаан мянга хоёр зуу) төгрөгийн алдаатай тооцоолсноос зарим сумдад 1.8-31.9 сая төгрөгөөр илүү, 0.2-17.9 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын Найм “Аймаг, нийслэлийн хөгжлийн сангаас сум, дүүргийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцох зарчим” дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.5-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцоолохдоо батлагдсан журамд заасан аргачлалын дагуу үнэн зөв тооцоолоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар, ахлах мэргэжилтэн Х.Энхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 64/А.2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ОНХС-ийн хөрөнгөөр “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрт тусгасан арга хэмжээтэй нийцээгүй, хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаагүй 182,900,000/нэг зуун наян хоёр сая есөн зуун мянга/ төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөөгүй зөрчлийг арилгаж, 2023 оны төсвийн төслийг өргөн барихдаа дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, Засаг даргын Тамгын газрын дарга П.Ариунбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 65/А2250433/ХӨА-2022 /
30-20-ШТА-ГА.

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Оновчтой бодлого-хариуцлагатай төсөв” (Аюулгүй орчин-Аз жаргалтай мөрөн) хөтөлбөрийн хүрээнд Галт суманд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хөргүүртэй махны агуулах барих, Хүнсний ногооны зоорь барих 2 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаагүй, гүйцэтгэл дутуу байхад нийт 151,800,000 нэг зуун тавин нэгэн сая найман зуун мянга/ төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.12-т “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсөл, арга хэмжээнүүдийн хийгдээгүй ажлыг зураг, төсөвт заасны дагуу бүрэн гүйцэтгүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтуяа, мэргэжилтэн Л.Занданмядагсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 06 өдөр

№ 66/A2250433/ХӨА-2022/
30-20-ШТА-ГА.

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтад анхаарал хандуулаагүйгээс өмч, хөрөнгө эзэнгүйдэж, үр ашгаа өгөхгүй, үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ